



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 108,704,590.00 (нэг зуун найман сая долоон зуун дөрвөн мянга таван зуун ерэн) төгрөгийн балансын үнэ, 108,146,608.36 (нэг зуун найман сая нэг зуун дөчин зургаан мянга зургаан зуун найман төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянзүрх дүүргийн Прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн захирал Х.Цогтбаатар, Баянзүрх дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ц.Батболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001603

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн  
186... дугаар тогтоолын хавсралт



Шинжлэх ухааны академийн Палеонтологи, геологийн хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй  
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
					Нэг бүрийн	Энгийн		
1	Дулааны шугам	м	1	1940/01/01	76,954,000.00	76,954,000.00		153,908,000.00
2	Цэвэр усны шугам	м	1	1940/01/01	4,765,600.00	4,765,600.00		9,531,200.00
3	Бохир усны шугам	м	1	1940/01/01	22,005,040.00	22,005,040.00		44,010,080.00
4	Хайс хашлага	ш	20	2007/01/01	602,500.00	602,500.00		1,205,000.00
5	Зүлэгжүүлсэн талбай	м2	340	2005/05/13	1,564,000.00	1,564,000.00		3,128,000.00
6	Навчит мод	ш	43	2005/05/13	103,200.00	103,200.00		206,400.00
7	Төв байрны засвар	м2	42	2012/01/01	1,974,450.00	1,974,450.00		3,948,900.00
8	Хүрээлэнгийн хайс	м3	13	2014/01/01	735,800.00	735,800.00	177,818.36	913,618.36
					<b>108,704,590.00</b>	<b>108,146,608.36</b>	<b>216,851,198.36</b>	
<b>Нийт дүн</b>					(нэг зуун найман сая долоон зуун дөрвөн мянга таван зуун ерэн)	(нэг зуун найман сая нэг зуун дөчин зургаан мянга зургаан зуун найман төгрөг гучин зургаан мөнгө)	(хоёр зуун арван зургаан сая найман зуун тавин нэгэн мянга нэг зуун ерэн найман төгрөг гучин зургаан мөнгө)	